

УЛААНБААТАР ХОТЫН 2023 ОНЫ АВАРГА ШАЛГАРУУЛАХ ӨСВӨР ҮЕИЙН БАДМИНТОНЫ ТЭМЦЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 10 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын 2023 оны өсвөр үеийн аварга шалгаруулах бадминтоны тэмцээн 2023 оны 09 дүгээр сарын 30-аас 10 дугаар сарын 01-ны өдрүүдэд Налайх дүүргийн Зэвсэгт хүчний 353-р цэргийн ангийн зааланд 2 өдрийн туршид амжилттай зохион байгуулагдлаа.

Тэмцээнийг Нийслэлийн биеийн тамир, спортын газар, Монголын бадминтон сонирхогчдын холбоо хамтран зохион байгуулж 24 байгууллагын 128 тамирчин 4 насны ангиллын 5 төрөлд хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж аваргуудаа тодруулав.

Тэмцээний нээлтийн үйл ажиллагаа



Нээлтийн үйл ажиллагаанд Налайх дүүргийн спортын хорооны дарга Д.Мөнхбаяр, Нийслэлийн биеийн тамир, спортын хорооны мэргэжилтэн Э.Мөнх-Эрдэнэ нар оролцож өсвөрийн тамирчдад амжилт хүсэж үг хэлэв.



Тоглолтын хэсгээс



12 хүртэл насны хөвгүүдийн ганцаарчилсан, 13-14 насны холимог хос , 17-18 насны охидын хос тоглолтууд шигшээ 16-н тоглолтууд явагдаж байна.



12-с доош насны ангиллын шагналт байранд шалгарсан тамирчид





13-14 насны ангиллын охидын ганцаарчилсан болон хөвгүүдийн хос тоглолтын тамирчид



Холимог хосын төрлийн тамирчид



15-16 насны охид хөвгүүдийн ганцаарчилсан төрлийн тамирчид



Хөвгүүдийн хос , холимог хос төрлийн тамирчид



17-18 насны тамирчид



Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнд оролцсон тамирчдын амжилтаар багийн дүн гаргаж Монголын бадминтон сонирхогчдын холбооноос урамшуулал олгов.

- 1-р байранд : 5 алт, 4 мөнгө, 4 хүрэл медалиар Улаанбаатар хотын “ Ёл клуб ”
- 2-р байранд 3 алт , 2 мөнгө, 3 хүрэл медалиар Налайх дүүргийн Голомт цогцолбор сургууль
- 3-р байранд 2 алт , 1 мөнгө, 2 хүрэл медалиар Улаанбаатар хотын “Шинэ – Эрин ” клубын баг тамирчид тус тус шалгарав.



Ёл клубын тамирчид



Налайх дүүргийн тамирчид



ТАЙЛАН ХЯНАСАН:
СПОРТ, НИЙТИЙН БИЕЙН
ТАМИРЫН ХЭЛТСИЙН ДАРГА

С.САРАНЦЭЦЭГ

ТАЙЛАН БИЧСЭН:
СПОРТ, НИЙТИЙН БИЕЙН
ТАМИРЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.МӨНХ-ЭРДЭНЭ